

2016 ОНЫ МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017-01-10

Улаанбаатар хот

МҮЦАЭХолбооны удирдах зөвлөл нь 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн бүх гишүүдийн ээлжит бус хурлаар сонгогдон үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд 2016.01.01-нээс 2016.12.31-ныг хүртэлх хугацаанд 12 удаа ээлжит хурал хуралдаж, 9 удаа ээлжит бус хурал зарлан хуралдуулжээ.

2016 онд МҮЦАЭХолбооноос явуулсан албан бичгийн тоо 123; Холбоонд ирсэн албан бичгийн тоо 66 бүртгэгдсэн байна.

Энэ хугацаанд СЗХ, МХБ, ҮЦТХТ, АТТ болон МҮЦБ-ийн удирдлагууд, түүнчлэн олон улсын байгууллагууд болох ЛСА, Дэлхийн банк, EBRD, Люксембургийн хөгжлийн агентлаг Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл, Японы санхүүгийн үйлчилгээний байгууллагуудын төслийн багийнхантай уулзалт зохион байгуулж зах зээлийн нөхцөл байдлыг танилцуулан, Холбооны болон гишүүн компаниудын байр суурийг илэрхийлж ажиллалаа.

Санхүүгийн Зохицуулах Хорооны зүгээс Холбооны үйл ажиллагааг дэмжиж мэргэжлийн холбоо болгон бэхжүүлэх, Төрийн байгууллагын зарим чиг үүргийг мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлэх боломж нөхцөлийн хүрээнд 2015 оны 6 дугаар сарын 10-нд анхны өөрийгөө зохицуулах байгууллага болгон бүртгэж хүлээн зөвшөөрсөн бөгөөд үүнтэй холбогдуулан СЗХ болон Холбоо нь 2015 оны 11 дүгээр сарын 11-нд санамж бичигт гарын үсэг зурж хамтран ажиллахаар болсон. Уг санамж бичигт өөрийгөө зохицуулах байгууллагыг бэхжүүлэх, ҮЦК-уудын үйл ажиллагааг дэмжиж чадавхижуулах, үнэт цаасны зах зээлийн харилцааны зохицуулалтыг төгөлдөржүүлж зах зээлийн хөгжлийг дэмжих гэсэн үндсэн гурван чиглэлээр 13 зорилт тавьж ажилласан.

МҮЦАЭХолбооны УЗ-ийн дарга Б.Өлзийбаяр болон ЕНБДарга Ц.Хуяг нар Филиппин улсын Манила хотноо 2016 оны “Азийн үнэт цаасны форум”-ын ээлжит хуралд оролцон Монгол улсын үнэт цаасны зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулга илтгэл тавьж, бусад орны туршлагаас судалж ажилласан. Тус арга хэмжээний үеэр Японы үнэт цаасны дилерүүдийн холбоо буюу өөрийгөө зохицуулах байгууллагатай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.

Үйл ажиллагааны тайлангийн хураангуйг дараах байдлаар танилцуулж байна. Үүнд:

1. Эрх зүй, зохицуулалтын чиглэлээр:

- Энэ хугацаанд Удирдах зөвлөл 8 удаа хуралдаж, Холбооны дүрэм, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулан, цаг үеийн тулгамдсан асуудлуудтай холбоотой 10 тогтоол гаргасан.
- СЗХ-ны 10 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “Санхүүгийн зах зээлийн үндэсний форум 2016”-д гишүүн байгууллагуудын хамтаар идэвхтэй оролцлоо.

- 2015 оны 1-р улиралд СЗХ, МҮЦАЭХолбоо, ҮЦТТХТ болон МХБ нар хамтран бүтэн нэг өдрийн турш МХБ болон МҮЦЭХолбоог ӨЗБ болсонтой холбоотойгоор зарим журмуудад өөрчлөлт оруулсан.
- Тайлант ажлын хугацаанд мэргэжлийн оролцогч байгууллагын дүрэм, журам саналаа өгч ажилласан. Үүнд:
 - i. СЗХ, МХБ болон АТТ
 - Онцгой нөхцөл байдлын журам
 - Мэргэшлийн шалгаруулалт явуулах, эрх олгох журам
 - Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам
 - Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам
 - Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам
 - Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам
 - Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам
 - Т+3 горимд шилжихтэй холбоотой гишүүдээс авсан санал
 - Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
 - Компанийн тухай хууль
 - МХБ-ийн гишүүнчлэлийн журам
 - МХБ-ийн бүртгэлийн журам
 - АТТ-ийн СЗХ-д бүртгүүлэх журмууд
- Холбооны бүх гишүүдийн Их хурлаар батлагдсан Холбооны дүрэм, журмуудад орсон нэмэлт өөрчлөлтүүдийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхээр өгсөн ба Хорооны зүгээс зарчмын хувьд зөвшөөрч, дүрэм журмын зарим нэгэн заалтыг өөрчлөхийг зөвлөсний дагуу зохих өөрчлөлтийг оруулан Хороонд бүртгүүлэхээр нийт гурван удаа хүргүүлсэн болно.
- Монгол улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрт санал өгөв.
- ЛІСА-гаас хэрэгжүүлж буй “Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Япон улсын Токио хотноо зохион байгуулагдах “Өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа” сэдэвт сургалтанд Холбооны УЗ-ийн гишүүн Н.Батгэрэл, Ёс зүйн хорооны гишүүн Г.Мөнх-Эрдэнэ, Холбооны дэд захирал П.Ган-Очир нарыг хамруулахаар Удирдах зөвлөлөөс шийдвэрлэж, гишүүд тус үйл ажиллагаанд амжилттай оролцов.
- Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлохоор чиглэл тус бүрээр нь Удирдах зөвлөлийн гишүүдэд хуваан өгч, нэгтгэн гаргав.
- Анод болон Зоос банкны эрх хүлээн авагчтай хамтран ажиллаж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох газруудад санал хүсэлтээ хүргүүлэв.
- Ногдол ашиг, ханшийн зөрүүгээс авах татварыг түдгэлзүүлэх талаар СЗХ, МХБ болон бусад оролцогч байгууллагуудтай хамтран ажиллаж, холбогдох төр, захиргааны байгууллага болох УИХ, УИХ-ийн зарим гишүүд, Засгийн газар болон Сангийн яаманд албан хүсэлтээ хүргүүлж ажилласан.

2. Гишүүдэд чиглэсэн үйл ажиллагаа:

- 2015-аас 2016 онд шилжих шинэ жилийн арга хэмжээгээр “Сикап ҮЦК” ХХК, “Дэү секьюритис монгол ҮЦК” ХХК, “Виртус ассет менежмент” ХХК-ийн

- гишүүнээр элсэх хүсэлтийг хүлээн авч Холбооны гишүүнээр элсүүлэн гишүүний гэрчилгээг гардуулан өгсөн/Англи, Монгол/.
- 2016 оноос өнөөг хүртэл нийт 3 ҮЦК-ийг шинээр гишүүнээр элсүүлсэн. /Тэсо Инвестмент, Новел инвестмент болон Бага хээр ҮЦК/
 - МХБ болон ҮЦТТТХТ-д гишүүний хураамжийн төлөлт болон бусад шимтгэл хураамжын талаар гишүүдээс судалгаа авч МХБ-ийн ТУЗ-ийн дарга, СЗХ-ны даргад МХБ ХК-ийн гишүүнчлэлийн хураамж, арилжааны шимтгэлийн талаар албан бичиг удаа дараа явуулж харилцан ойлголцолд хүрч гишүүний хураамжийн хэмжээг 50 ба түүнээс дээш хувиар бууруулав.
 - МХБ, ҮЦТТТХТ, СЗХ болон МҮЦАЭХолбоо хамтран Өөрийгөө зохицуулах байгууллага бий болсонтой холбогдуулан “Mongolica Resort” дээр хоёр өдрийн хугацаанд ажиллан зарим журмуудыг засч шинэчилсэн. Үүнд:
 - i. “МХБ-ийн гишүүнчлэлийн журам”-д МҮЦАЭХолбооноос **3.3.3-т** “*Гишүүн нь Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн бол жилийн үйлчилгээний хөлсөөс 10 хувь хөнгөлнө*”, мөн **3.3.2-т** “*Гишүүн нь бирж дээр хийгдсэн тухайн жилийн нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх гүйлгээг дангаар хийсэн бол дараа жилийн гишүүнчлэлийн жилийн үйлчилгээний хөлсөөс 50 хүртэлх хувиар хөнгөлж болно;*” гэх заалтуудыг оруулж 2016 оны гишүүний хураамжаас 20 гаруй ҮЦК, 2017 оны гишүүний хураамжаас нийт 44 ҮЦК 10 хувийн хөнгөлөлт эдлэхээр болсон төдийгүй нэр бүхий 5 ҮЦК нь нэмж 10 хувийн хөнгөлөлт эдлэхээр болсон.
 - ii. СЗХ-оос үнэт цаасны зах зээл дээр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулах эрх авсан зохицуулалттай этгээдүүдийг мэргэжлийн холбоонд нэгтгэх үүднээс СЗХ-ны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын **3.1.2-д** “*Зохицуулалттай этгээд нь ҮЦЗЗ-ийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооны гишүүн байна*” гэсэн заалт оруулснаар Холбоонд гишүүн элсүүлэх эрх зүйн нөхцөл бүрдсэн.
 - Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалтыг хоёр удаа амжилттай зохион байгуулж, нийт 148 мэргэжилтэнд эрх олгосон.
 - Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтыг 2016 оны 10-р сард зохион байгуулж нийт 18 хүнд гэрчилгээ олгов.
 - 2016 оны 2-р сарын 4-ны өдөр Кастодиан банкны танилцуулгыг Хорооноос эрх авсан 3 банкттай хамтран зохион байгуулж, гишүүн компаниудын мэргэжилтнүүдэд мэдээлэл өгөв.
 - “Зууны мэдээ” сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулж, Холбоо болон гишүүн байгууллагууд уг сонинд мэдээ, мэдээлэл, зар оруулахад 50%-ийн хөнгөлөлт эдлэхээр боллоо.
 - ЛИСА-гийн мэргэжилтнүүд “Өөрийгөө зохицуулах байгууллага” -ын талаар ҮЦК-ийн мэргэжилтнүүдэд зориулсан семинар хийв.
 - ЛИСА-гийн төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Олон нийтийн санхүүгийн боловсрол” сэдэвт сургалт семинарт гишүүн байгууллагын 15 мэргэжилтэнг хамруулав.
 - СЗХ, Японы ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага ЛИСА, МҮХАҮТанхимтай хамтран “ПРО болон давхар бүртгэл” сэдэвт семинарт мэргэжилтнүүдийг хамруулав.
 - 10-р сарын 1-нд Цэцээ гүн рүү явган аялалыг зохион байгуулсан гишүүн байгууллагуудын 50 гаруй хүн оролцсон.

- “Новел инвестмент ҮЦК” ХХК-ийг Холбооны гишүүнээр элсүүлэв.
- МХБ-ийн 2012 оны гишүүний хураамжийн асуудалтай холбоотой хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх хуралд оролцож анхан шатны шүүхийн шийдвэр нь МХБ-ийн нэхэмжлэхийг хүлээн авч шийдвэрлэсэн ч давж заалдах шатны шүүхийн шийдвэр ШӨХТГ-ийн талд гаргасан. Уг шүүх хуралд МҮЦАЭХ нь гуравдагч этгээдээр оролцсон болно.
- Японы ОУ-ын хамтын ажиллагааны байгууллагын “Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн багтай нягт хамтран ажиллаж ирсэн. Үүнд:
 - i. Гишүүн байгууллагуудын чадавхыг сайжруулах үүднээс IPO, давхар бүртгэл болон Өөрийгөө зохицуулах байгууллага сэдвээр сургалт зохион байгуулсан
 - ii. Эрх олгох сургалтын хөтөлбөрийг сайжруулж ажиллахаар болсон төдийгүй сургалтын гарын авлага боловсруулах ажлыг эхлүүлсэн. Үүнтэй холбоотой хөрөнгө оруулалт, зуучлал, аттестатчилах сургалтын хөтөлбөрүүдийг Англи хэлнээ орчуулж танилцуулсан.
 - iii. Мөн эрх олгох сургалтын агуулгыг танилцуулж, дүн шинжилгээ хийлгэсэн.
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Хорооноос тавьсан шаардлагын талаар гишүүн ҮЦК-уудын төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж, гишүүдээс ирсэн саналыг нэгтгэн Хороонд хүргүүлсэн ба уг асуудлыг нэг жилийн хугацаагаар хойшлуулсан.

3. Зах зээлд чиглэсэн олон нийтийн хамарсан үйл ажиллагаа

- СЗХ-оос санаачлан Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж нэгдсэн шийдэлд хүрэх зорилгоор Говь Ресорт амаралтын газар вакумжуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан мэргэжлийн оролцогч байгууллагуудын удирдлага болон ахлах мэргэжилтнүүдийг хамруулсан.
- МҮЦАЭХолбооны санаачилгаар МҮЦАЭХ, МХБ, ҮЦТХТ, АТТ болон МҮЦБирж-ийн 5 байгууллага хамтран ажиллах санамж бичгийн ажлын хэсэг байгуулж, санамж бичгийн төслийг боловсруулж ажиллав.
- Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн байгууллагууд болох “МХБ” ТӨХК, “ҮЦТХТ” ХХК, “АТТ”ХХК, “Монголын үнэт цаасны бирж” ХХК, МҮЦАЭХ нар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.
- Түүнчлэн JICA-ийн “Хөрөнгийн зах зээлийн чадавхыг сайжруулах” төслийн хүрээнд хамтран ажиллаж “Хөрөнгийн зах зээлийн долоо хоног” хөтөлбөрийг зохион байгуулах ажлыг хэсгийг бүрдүүлж бэлтгэл ажлыг хангав.
- Үнэт цаасны зах зээл дээр тулгамдаж буй асуудлаар судалгаа явуулж Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн бодлогын талаарх санал асуулгын судалгааг ҮЦК-иудын харилцагчид болох хөрөнгө оруулагч нарын дунд явуулав.
- 10-р сарын 26-ны өдөр Төрийн ордны Их танхимд “Нэг зорилго - Нэгдсэн шийдэл” хэлэлцүүлгийг зохион байгуулж, нийт 500 гаруй зочин төлөөлөгч уг өдөрлөгт оролцсон.
- ШУТИС-ийн дэргэдэх Бизнесийн урдирлага, хүмүүнлэгийн сургуулиас жил бүр зохион байгуулдаг “Бид ирээдүйн хөрөнгө оруулагчид 2016” тэмцээнд дэмжигч байгууллагаар оролцов.

- Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагууд хамтран “Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээ”-г хамтран зохион байгуулж нийт 90 гаруй зочид, төлөөлөгчид оролцов.
- Анх удаа Хөрөнгийн зах зээлийг төлөөлж МҮЦАЭХолбооны УЗ-ийн дарга “Хөрөнгийн зах зээл - Хөгжлийн гарц” сэдвээр эдийн засгийн форум буюу “Монголын эдийн засгийн чуулган 2016” уулзалтад оролцож илтгэл тавьсан.
- Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн бодлогын зөвлөлийн гишүүн болсон.
- Эдийн засгийн байнгын хорооноос зохион байгуулсан Монгол улсын 2017 оны мөнгөний бодлогод анх удаа хөрөнгийн зах зээлийг төлөөлөн оролцож саналаа хүргүүлсэн.
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Даажамбаар ахлуулсан банк, санхүү, даатгалын салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгохтой холбоотой бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, даатгал болон үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд МҮЦАЭХолбооноос УЗ-ийн Дарга Б.Өлзийбаяр томилогдож ажиллахаар болсон.
- Монголын бизнесийн зөвлөлийн дэргэдэх Хөрөнгийн зах зээлийн ажлын хэсэгт Б.Өлзийбаяр томилогдсон ба үүний дагуу тухайн байгууллагаас зохион байгуулсан “Business summit” хэлэлцүүлэгт илтгэл тавьсан.
- Засгийн газрын бондыг хөрөнгийн биржээр арилжаалах зорилгоор ЗГ бондыг арилжаалах гэрээг боловсруулж МХБ-тэй хамтран ажилласан.

4. Холбооны дотоод үйл ажиллагаа

- Хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсаны 25 жилийн ой болон Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсаны 10 жилийн ойн арга хэмжээнд манай холбоо идэвхтэй оролцож Хөрөнгийн зах зээлийн салбарын нийт 20 мэргэжилтэн салбарын болон төрийн одон, медалаар шагнуулж Холбооны удирдлага МХБ-ийн удирлагатай хамт шагнал авсан мэргэжилтнүүдэд хүлээн авалт зохион байгуулж дурсгалын бэлэг гардуулсан.
- 2015 50 гаруй хүний бүрэлдхүүнтэй анх удаа супер шагнал болон гарын бэлэгтэй жилийн арга хэмжээ зохион байгуулсан ба 2016 оны шинэ жилийн үйл ажиллагааг улам өрөгжүүлж санамж бичигт гарын үсэг зурсан байгууллагуудтай хамтран Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулж хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагуудын оны шагналт мэргэжилтнүүдийг тодруулсан. /Холбооны УЗ-ийн гишүүдийг анх удаа үнэ төлбөргүй урьж оролцуулсан/.
- МҮЦАЭХолооны дотоод мэдээллийг архивыг цэгцэлж нэгдсэн сервертэй болсон ба хагас жил тутам уг мэдээллийг архивладаг болсон.
- Холбооноос явуулсан бичиг, судалгаа, хэлэлцүүлэг, хууль дүрэм, журмын санал болон хүсэлтийг цахим файлаар цэгцэлж мэдээллийг хялбар нээлттэй болгов.
- МҮЦАЭХолбооны санхүү бүртгэлийн асуудлыг шинэчилж сайжруулсан. Үүнд:
 - i. БААЗ нягтлан бодох бүртгэлийн программ ашиглаж санхүүгийн бүртгэлийг ил тод болгов.
 - ii. Кассын тайланг сар бүр хөтөлж бэлэн мөнгөний бүртгэлийг нээлттэй хялбар болгов
 - iii. Харилцахын тайлан болон кассын тайланг цаг хугацааны дараалал нэгтгэж архивлав.
- Хөрөнгийн зах зээлийн мэдээ, мэдээлэл болон Холбооны үйл ажиллагааны талаар гишүүдэд мэдээлэл хүргүүлдэг болсон.

- i. Долооо хоногийн тойм
- ii. Онцлох үйл явдал
- МҮЦАЭХолбооны цахим хуудсын вэб хостинг болон домэйн нэрийн сервирийг датаком руу шилжүүлж цахим хуудсыг ажилд оруулсан.
- МҮЦАЭХолбооны олон нийтийн сүлжээний хуудсуудыг идэвхжүүлж ажиллан Холбооны үйл ажиллагааг олон нийтэд таниулж сурталчилсан.
- 2015 оны гишүүний татварын өглөгийг бүх гишүүдийн Их хурлаас өмнө нэхэмжилж 50 орчим хувийг барагдуулав.
- Холбооны бүх гишүүдийн Их хурлыг 2016 оны 03-р сарын 04-ны өдөр зохион байгуулж Холбооны дүрэм, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулж батлуулав.
- СЗХ болон Холбоо хамтран танилцах үзлэг зохион байгуулах шийдвэр гарган нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй зурган ажлыг хэсэг гарч үйл ажиллагаа явуулж буй бүх үнэт цаасны компаниуд тухайн үеийн нөхцөл байдлыг танилцуулж ажиллан судалгааг гаргаж мэдээллийг шинэчилж ажилласан ба Холбооны ёс зүйн дүрмийг бүх гишүүдэд хүргүүлсэн.
- Холбооны Аудитын хороо Удирдах зөвлөлийн хуралд санал болгосон аудитын компаниудаас “Тэд-Аудит” ХХК-ийг сонгож, Холбооны 2016 оны 1-р улирлын санхүүгийн тайланд аудит хийлгэв.
- Холбооны вэб сайтын домэйн нэрийг шилжүүлж сайтын бүтцийг дахин боловсруулж мэдээллийг шинэчлэн оруулав.

5. Бусад

- МҮЦАЭХолбооны УЗ-ийн 2016 оны 03-р сарын 01 өдрийн 15-р тогтоолоор УЗ-ийн хараат бус гишүүдэд үйл ажиллагааг идэвхжүүлж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор урамшуулал хөлс олгохоор болов.
- БиДиСек ҮЦК-аас жил бүр зохион байгуулдаг “BDSec Cup” өдөрлөгийн 10 жилийн ойн арга хэмжээнд зориулан Талархлын бичиг болон дурсгалын зүйлээр шагнав.
- Филиппин улсын Манила хотод зохион байгуулагдсан ASF forum-д УЗ-ийн дарга Б.Өлзийбаяр, ЕНБД Ц.Хуяг нар оролцож олон улсын хөрөнгийн зах зээлийн туршлагаас судалж ажилласан ба Японы үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болох Ази номхон далайн бүсийн өөрийгөө зохицуулах байгууллагын том төлөөлөл болох JSDA байгууллагатай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.
- Хорооноос зохион байгуулж буй Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн үг хэллэг, нэр томъёоны тайлбарыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт УЗ-ийн гишүүн Г.Алтансүх, Ёс зүйн хорооны гишүүн Г.Мөнх-Эрдэнэ нарыг оролцуулж байна.
- МҮЦАЭХолбооны УЗ-ийн гишүүн Ч.Жаргал Япон улсын Токио хотноо жил бүр зохион байгуулагддаг “Asia Securities Forum Tokyo Round Table 2017”-д амжилттай оролцсон.
- 6. “Өөрчлөгч” эдийн засгийн сэтгүүлчдийн клубтэй хамтран ажиллаж хэд хэдэн удаагийн сургалт семинар зохион байгуулсан. Үүнд:
 - Эдийн засгийн сэтгүүлчдэд зориулан хөрөнгийн зах зээлийг таниулах, сурталчлах чиглэлээр сургалт зохион байгуулсан.
 - “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн өнөөгийн нөхцөл байдал болон ЭТТ хувьцааг хөдөлгөх арга замууд” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан ба үүнд “ЭТТ” ХК, СЗХ, МХБ, ҮЦК болон МҮЦАЭХолбооны төлөөлөл оролцож эдийн засгийн сэтгүүлчдэд цаг үеийн мэдээлэл хүргүүлсэн.

- Мөн “Төрийн өмч хувьчлал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож МҮЦАЭХолбооны байр суурийг илэрхийлсэн.
7. МҮЦАЭХолбооны зүгээс зах зээлийн нөхцөл байдал болон хөрөнгийн зах зээлийг олон нийтэд таниулах зорилгоор удаа дараа хэвлэлийн бага хурал зохион байгуулсан. Үүнд:
- “ЭТТ” ХК-ийн данс нээх үйл ажиллагаатай холбоотойгоор олон нийтэд бие даасан болон хамтарсан хэвлэлийн бага хурал зарлаж, үнэн зөв мэдээллийг хүргэж ажилласан.
 - “Нэг зорилго - Нэгдсэн шийдэл” хэлэлцүүлгийн зохион байгуулалтын хүрээнд салбарын оролцоог идэвхижүүлэх зорилгоор ХБХ зарлаж мэдээлэл хийсэн.
 - Дээрх хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг МХБ, ҮЦТХТ, АТТ, МҮЦБирж, МҮХАҮТанхим болон МҮЦАЭХолбоо нар хамтран хэвлэлийн бага хурал зарлаж УИХ, Засгийн газар болон СЗХ-д хүргүүлсэн.
8. МҮЦАЭХолбооны Хүндэт Ерөнхийлөгч болох саналыг УИХ-ын гишүүн Д.Цогтбаатарт тавьсан бөгөөд бидний саналыг хүлээн авч манай Холбооны хүндэт Ерөнхийлөгчөөр ажиллахаар болсон. Улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр лобби групп байгуулах, УИХ болон бусад холбогдох төрийн эрх барих дээд байгууллагуудад хөрөнгийн зах зээлийн талаар эерэг мэдээлэл өгч зах зээлийг дэмжиж ажилаахаар болсон.

2016 онд шагнал авсан мэргэжилтнүүд:

1. Төрийн дээд одон, медаль

1.1 “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”

- Т.Монхор /Алтан хоромсог ҮЦК” ХХК, Гүйцэтгэх захирал/

1.2 “Алтан гадас”

- Б.Батсайхан /Тулгат чандмань баян ҮЦК” ХХК, Гүйцэтгэх захирал/
- Ш.Эрдэнэ /Зэргэд ҮЦК” ХХК, Гүйцэтгэх захирал/
- Л.Цэвээнравдан /МҮЦАЭХ-ны Хяналтын зөвлөлийн дарга/
- Ж.Очирсүх /Дархан брокер ҮЦК” ХХК, Гүйцэтгэх захирал/

1.3 “Хөдөлмөрийн хүндэт медаль”

- Т.Цогтбаяр /МҮЦАЭХ-ны Хяналтын зөвлөлийн гишүүн/
- М.Отгонбаатар /Монсек ҮЦК” ХХК, Гүйцэтгэх захирал/
- В.Баттулга /Масдак ҮЦК” ХХК, Гүйцэтгэх захирал/
- М.Бүрэнбаяр /Санар ҮЦК” ХХК, Гүйцэтгэх захирал/
- Д.Амгалан /Булган брокер ҮЦК” ХХК, Гүйцэтгэх захирал/
- Д.Бат-Эрдэнэ /Дэлгэрхангай секьюритис ҮЦК” ХХК, Дилер/

2. Санхүүгийн зохицуулах хороо

2.1 Хорооны “Жуух бичиг”

1. Ц.Хуяг /МҮЦАЭХ, ЕНБД/
2. Т.Хулан /“Гаули ҮЦК” ХХК, Дотоод хяналтын ажилтан/

2. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

3.1 “Хөрөнгийн зах зээлийн тэргүүний ажилтан цол тэмдэг”

1. Э.Амарбаясгалан /Голомт капитал ҮЦК” ХХК, Гүйцэтгэх захирал/
2. Г.Золжаргал /Голомт капитал ҮЦК” ХХК, Ерөнхий нягтлан бодогч/
3. П.Оюунтуяа /МҮЦАЭХ, Сургалт хариуцсан менежер/

3. МЗХ-ны “Тэргүүний залуу” алтан медаль

1. Г.Золжаргал /Голомт капитал ҮЦК” ХХК, Ерөнхий нягтлан бодогч/
2. Т.Хулан /“Гаули ҮЦК” ХХК, Дотоод хяналтын ажилтан/
3. Ц.Чанцал /“Гаули ҮЦК” ХХК, Дилер/

4. МҮЦАЭХолбоо-ны “Хүндэт өргөмжлөл”

- Л.Цэвээнравдан /МҮЦАЭХ-ны Хяналтын зөвлөлийн дарга/